



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,  
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2024.03.28 № 04/630  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН  
ДАРГА НАРТ

### Зөвлөмж хүргүүлэх тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9.1 дэх хэсэгт заасан нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд түүний авч байсан сарын тэтгэврийн 20 хувиар тооцсон дүнгээр нөхөр эсхүл эхнэрийн сарын тэтгэврийг нь нэмэгдүүлэх хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэхээр тус газрын 2024 оны 01/82 дугаар албан бичгээр хүргүүлсэн зөвлөмжид дараах нэмэлт зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч нь Гэр бүлийн тухай хуулийн 7.1-д зааснаар гэрлэлтээ бүртгүүлсэн байна. Нас барсан болон гэр бүлийн гишүүн өндөр насны тэтгэвэр авагчийн гэрлэлтийн бүртгэлийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын системээс татан авах, уг системээс авах боломжгүй эсхүл гэрлэлтийн гэрчилгээний мэдээлэл нь зөрүүтэй тохиолдолд дараах баримт бичгийг үндэслэн тухайн гэр бүлийн гишүүн эхнэр (нөхөр)-ийн хамт амьдарч байсан хугацаа (20 жил)-г тодорхойлно:

1. Гэрлэлтийн гэрчилгээ;

2. Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөхөөс өмнө буюу 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө гэрлэлтээ бүртгүүлсэн өндөр насны тэтгэвэр авагчийн хувьд гэрлэлтийн гэрчилгээнд гэр бүл болсныг тогтоосон (бичсэн) он, сар, өдрөөр;

3. 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш гэрлэлтээ бүртгүүлсэн өндөр насны тэтгэвэр авагчийн хувьд гэрлэлтийн гэрчилгээнд бүртгэсэн он, сар, өдрөөр;

4. Өндөр насны тэтгэвэр авагчийн гэрлэлтийн гэрчилгээнд гэр бүл болсныг болон бүртгэсэн хугацаа нь 20 жилээс бага боловч төрүүлсэн болон үрчлэн авсан 20 ба түүнээс дээш насны хүүхэдтэй бол хүүхдийнх нь гэрчилгээг үндэслэн;

5. 20 жил ба түүнээс дээш жил хамт амьдарсныг нотлох баримт бичиггүй тохиолдолд шүүхийн шийдвэр зэрэг болно.

Иймд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу тэтгэвэр авагчийн хүсэлтийг хүлээн авч, тэтгэврийн нэмэгдлийг тооцон мөн хуулийн 23.6 дахь хэсэгт заасан хугацааг баримтлан олгох нь зүйтэй.

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, СУДАЛГААНЫ  
ГАЗРЫН ДАРГА Ц.ГАНЦЭЦЭГ



My doc.BHSG A-4 /24.03/ sar

1524070783